




Долоо хоног тутмын мэдээ мэдээлэл - Монголын Мянган сорилтын сан

№3 (2)

2021.04.19

## БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗАЛУУ МАНЛАЙЛАГЧИД УЛААНБААТАР ХОТЫН НИЙТ УС ХАНГАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРТЭЙ ТАНИЛЦЛАА



Монгол Монголын Мянган сорилтын сангийн Гүйцэтгэх захирал Э.Содонтогос “Зориг сан” ТББ-аас санаачлан хэрэгжүүлдэг “Байгаль орчны манлайлал” хөтөлбөрийн цахим уулзалтад зочин илтгэгчээр оролцож, Мянган сорилтын хоёр дахь Компакт гэрээгээр хэрэгжүүлж буй Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй танилцууллаа. Цахим уулзалтад “Байгаль орчны манлайлал” хөтөлбөрт шалгарсан байгаль орчны шилдэг 22 залуу мэргэжилтнээс гадна “Зориг сан” ТББ-ын төлөөлөл оролцов. Уулзалтаар Монголын

Мянган сорилтын сангийн Гүйцэтгэх захирал Э.Содонтогос энэ үеэр “Монголын Мянган сорилтын сангийн зүгээс чадварлаг ажиллах хүчнийг одооноос бэлтгэх чиглэлд Ус сувгийн удирдах газар болон холбогдох сургуулиудтай хамтран ажиллана. Монголд анх удаа Ус гүн цэвэршүүлэх, Хаягдал ус дахин боловсруулах томоохон үйлдвэрүүд байгуулагдаж байгаа учраас энэ чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг сургуулиудын хичээлийн хөтөлбөрт өөрчлөлт оруулах шаардлага ч гарах болов уу. Тиймээс та бүхэн маань одооноос илүү их хичээж, уншиж судалж, мэргэжилдээ дурлаж, шинжлэх ухаанч, эрэл хайгуулч байж, өөрийгөө тасралтгүй хөгжүүлж бэлтгэх хэрэгтэй” хэмээн захив.

[Эх сурвалж: Монголын Мянган сорилтын сан](#)

## “УЛААНБААТАР УС-ЦЭВЭР ОРЧИН 2021” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ОНОЛ ПРАКТИКИЙН ХУРЛЫГ ЦАХИМААР ЗОХИОН БАЙГУУЛНА



Нийслэлийн хүн ам өсөн нэмэгдэж, үйлдвэржилт хурдацтай хөгжихийн хэрээр агаар, хөрс, усны бохирдол, цэвэр усны нөөц, ундны усны аюулгүй байдлын асуудал хурцаар тавигдах болсонтой холбогдуулан оновчтой шийдэл эрэлхийлэх, судалгаа шинжилгээний чиглэлийг тодорхойлох, холбогдох салбарын байгууллагууд, их дээд сургууль, эрдэмтэн судлаачид, хувийн хэвшлийнхний хамтын ажиллагааг нягтруулах, мэдлэг, туршлага солилцох зорилгоор Барилга, хот байгуулалтын яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн засаг даргын Тамгын газар болон Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Барилга,

архитектурын сургууль хамтран “Улаанбаатар Ус-Цэвэр Орчин 2021” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг цахимаар зохион байгуулах гэж байна. Хуралд усны болон хүрээлэн буй орчны салбарын төрийн болон төрийн бус байгууллагын мэргэжилтэн, инженер техникийн мэргэжилтэн, эрдэмтэн судлаачид, багш, оюутан болон хувь хүмүүс оролцож, хот, суурины ус хангамж, ариутгах татуургын систем ба усны аюулгүй байдал, ус цэвэрлэгээний шинэ технологи, тоног төхөөрөмж, саарал ус ашиглалт зэрэг олон сэдвээр илтгэл тавих боломжтой юм байна. Эрдэм шинжилгээний хурал 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдөр болох бөгөөд хэлэлцүүлэх илтгэлүүдийг 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийг дуустал [erkhee9191@gmail.com](mailto:erkhee9191@gmail.com) хаягаар хүлээн авах аж.

[Эх сурвалж: ШУТИС-ийн Барилга, архитектурын сургууль](#)

## ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Монголын Усжуулагчдын Холбооны зүгээс ХХААХҮЯам-тай хамтран ажиллах ажлын хүрээнд **Усны барилга байгууламжийн чиглэлээр барилга угсралтын ажил гүйцэтгэдэг мэргэжлийн компаниудын чадавхын судалгаа** гаргаж, тус яаманд хүргүүлэхээр ажиллаж байгаа юм байна. Энэхүү судалгаанд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг компаниудаас гадна хөдөө орон нутгийн компаниуд идэвхтэй оролцохыг уриалж байгаа бөгөөд яамны төлөөлөлтэй зөвшилцөж гаргасан судалгааны загварыг [https://drive.google.com/file/d/11yyBUEDApQ\\_P85tgbXFKmCSBp4-aKsFp/view?fbclid=IwAR083p6k05zV4cyRltYm26zWIII0c9RNmuVaf7xdWgHncG4V2XGjDQtnyCQ](https://drive.google.com/file/d/11yyBUEDApQ_P85tgbXFKmCSBp4-aKsFp/view?fbclid=IwAR083p6k05zV4cyRltYm26zWIII0c9RNmuVaf7xdWgHncG4V2XGjDQtnyCQ) холбоосоор татаж авна. Бөглөсөн судалгааг Усжуулагчдын холбооны [mhea.mn2013@gmail.com](mailto:mhea.mn2013@gmail.com) хаягаар хүлээн авах юм байна. [Эх сурвалж: Монголын Усжуулагчдын холбоо](#)

## ШИНЭ ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ

Олон улсын усны салбарын нэр хүндтэй “Water Innovations” сэтгүүлийн 2021 оны 3 дугаар сарын дугаарт нийтлэгдсэн Израилийн хүрээлэн буй орчны инженер Лиор Эшедийн **“Ус дахин ашиглалт аврал болох нь: Тогтвортой ирээдүйн төлөө хотын унд, ахуй, үйлдвэрийн хаягдал усыг дахин боловсруулах тухайд”** (Reuse to the Rescue: Recycling Municipal and Industrial Wastewater For A Sustainable Future) нийтлэлийг онцолж байна. Ус дахин ашиглалт гэж юу болох, АНУ, Сингапур болон бусад улс орны ус дахин ашиглалт, аж үйлдвэрийн хэрэгцээнд усыг дахин ашиглах, унд ахуйн хэрэгцээнд усыг дахин ашиглах, ус дахин ашиглалтыг шинэ түвшинд гаргах нь зэрэг сонирхолтой сэдвүүдийг хөндсөн энэхүү нийтлэлийг <https://bit.ly/3apabJE> холбоосоор унших боломжтой.

## ОЛОН УЛСЫН ЦАХИМ ХУРЛУУД

“Water and Wastewater Treatment” байгууллагаас **“Усны салбарын хөрөнгийн менежмент”** сэдэвт цахим хурал 2021 оны 4 дүгээр сарын 21, 22-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулна. (Төлбөртэй) [Эх сурвалж: WWT Online](#)  
“Water Online” сэтгүүлээс **“Усны цахим экспо”** (Virtual Water Expo)-г 2021 оны 4 дүгээр сарын 21, 22-ны өдрүүдэд зохион байгуулна. (Үнэ төлбөргүй) [Эх сурвалж: Water Online](#)